

**ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ЗАХИАЛГААР ГАДААД УЛСЫН АКАДЕМИ, ИХ, ДЭЭД
СУРГУУЛИУДАД СУРАЛЦАЖ БУЙ АЛБА ХААГЧ, СУРАЛЦАГЧДЫН
ЦАЛИНГИЙН ЗАРДЛЫН ТАЛААР**

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны “Журам шинэчлэн батлах тухай” А/355 тушаалаар баталсан “Гадаадын их, дээд сургуульд хууль сахиулах байгууллагын алба хаагчийг сонгон шалгаруулах, суралцуулах журам”-ын 5.2.1.-т Тухайн байгууллагын захиалгаар гадаадын академи, их дээд сургуульд адъюнктур, магистр, бакалаврын зэргээр суралцах эрх авсан боловч төрийн сангийн зээлд хамрагдаж чадаагүй алба хаагчдад ажиллаж байсан **албан тушаалын ангиллын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний тэтгэлэг, цолны нэмэгдлийг сар бүр** олгоно, 5.2.2 “ерөнхий боловсролын сургууль төгсөгч болон магадлан итгэмжлэгдсэн их, дээд сургуульд суралцаж байгаад тухайн байгууллагын захиалгаар гадаадын академи, их дээд сургуулийн бакалаврын зэрэг олгох сургалтад элсэн суралцагчдад Засгийн газраас тогтоосон төрийн тусгай албан тушаалын цалингийн сүлжээний доод хэмжээгээр үндсэн цалинг тооцож, үндсэн цалинтай тэнцэх хэмжээний тэтгэлэг, цолны нэмэгдлийг сар бүр олгоно гэсний дагуу суралцагчдын цалин бусад зардлыг олгож байна.

Гадаадын академи, их, дээд сургуульд суралцагчдын зардлын төсөв 2024 онд 1.276.092.799 төгрөг зарцуулагдсан байна.

Гадаадын их, дээд сургуульд суралцагчдад олгосон зардлыг сүүлийн 3 жилээр харуулбал /сая төгрөг/:

| Үзүүлэлт | 2021 он | | 2022 он | | 2023 он | | 2024 он | |
|---------------------------|--------------|-------|--------------|-------|----------------|-------|----------------|---------|
| Цалин, цол | 87 | 711,0 | 88 | 768,2 | 107 | 959,1 | 126 | 1.246,1 |
| ЭМД а/о-с | 87 | 14,2 | 88 | 11,5 | 107 | 19,1 | 126 | 24.9 |
| Замын зардал | 1 | 80,4 | 80 | 74,3 | 81 | 70,3 | 5 | 5.0 |
| Бүгд дүн /сая төг/ | 805,6 | | 748,3 | | 1.048,6 | | 1.276,0 | |

Суралцагч 1 алба хаагчид олгож буй тэтгэлгийн дүнг дунджаар харуулбал /төгрөг/:

| Журмын заалт | ЗГ-ын 2019 оны 472 тогтоол | | | | |
|--------------|----------------------------|------------------|---------------|-------------------|---------------|
| | Цалин зэрэглэл | Тэтгэлэг /сар/ | ЭМД а/о /сар/ | Тэтгэлэг /жил/ | ЭМД а/о /жил/ |
| 5.2.1. | ТТ-2-ТТ-9 | 2.207.400 | 44.148 | 26.488.800 | 529.776 |
| 5.2.2. | ТТ-12 | 1.375.000 | 27.500 | 16.500.000 | 330.000 |

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР